

Сошиалаар шидье, сошиалаар шийдье!



Таны ЦАГийг хэмнэж, санхүүгийн харилцааг хамгийн хялбараар шийдэх SocialPay үйлчилгээг танилцуулж байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОМЖУУД

1. Мөнгө илгээх

- Утасны дугаар, и-мэйл хаяг болон Twitter, Facebook сүлжээ ашиглан мөнгө шилжүүлэх
- Мөн өөрт ойрхон байгаа хүмүүс рүүгээ GPS байршил ашиглан мөнгө илгээх
- 2. Мөнгө нэхэмжлэх
 Бусдаас мөнгө авах, төлбөр хуваалцах хүсэлтээ олон хүн рүү зэрэг нэхэмжлэх
- 3. Чатлах
 - Хувийн чат үүсгэж харилцах
- 4. Онлайнаар бүртгүүлэх
 Голомт банкны харилцагч болохын тулд заавал банкны салбар орох шаардлагагүй, онлайнаар бүртгүүлэх боломжтой

АППЛИКЕЙШН ХЭРХЭН СУУЛГАХ ВЭ?

- App Store, Play Store-ийн Search хэсэгт "SocialPay" гэж бичиж хайх - Free, Install товч дээр дарж татаж авах

УТСАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- iOS 9.0-ээс дээш, Android 4.0-ээс дээш үйлдлийн системтэй байх - Байршил тодорхойлохын тулд GPS-ээ тохируулсан байх

ХЭРХЭН АППЛИКЕЙШН РУУ НЭВТРЭХ ВЭ?

ХЭРХЭН ТОХИРГОО ХИЙХ ВЭ?



Интернэт банкны эрхээ ашиглан нэвтэрнэ.

Хэрэв та Голомт банкны харилцагч болж амжаагүй бол онлайнаар бүртгүүлэх боломжтой.

SocialPay үйлчилгээний нөхцөл болон уг үйлчилгээг ашиглахад анхаарах зүйлстэй сайтар танилцана уу.



1. Бүртгэлтэй данс холбох

Таны Голомт банканд бүртгэлтэй нийт дансны жагсаалт харагдах бөгөөд үүнээс нэг дансыг Сошиал дансаар сонгоно. Сошиал данс гэдэг нь сошиал сувгуудаар мөнгө хүлээн авах болон шилжүүлэх дансыг хэлнэ.





2. Утасны дугаар баталгаажуулах

Гар утасны дугаараа оруулан холбох товч дарсанаар танд 4 оронтой код мессэжээр очих ба уг кодыг оруулж дугаараа баталгаажуулна. Уг үйлдлийг хийснээр та цаашид утасны дугаараараа дамжуулан мөнгө хүлээн авах боломжтой болно.



3. Сошиал пин тохируулах

Гүйлгээ хийх үед ашиглагдах 4 тооноос бүрдэх сошиал пин код үүсгэнэ. Мөн Touch ID хурууны хээ уншигчийг холбож гүйлгээгээ баталгаажуулах боломжтой.

Аппликейшний "холболт" хэсэг рүү орж дээрх мэдээллээ шинэчлэх боломжтой

МӨНГӨ ИЛГЭЭХ БОЛОН НЭХЭМЖЛЭХ

ЛАВЛАГАА



Шилжүүлэх мөнгөн дүнгээ оруулан "Илгээх эсвэл Нэхэмжлэх" товч дарна.

Үлдэгдэл хүрэлцэж байгаа эсэхийг "Сошиал дансны үлдэгдэл шалгах" хэсгээс харах боломжтой.

Facebook, twitter, и-мэйл хаяг болон утасны дугаар дээр бүртгэлтэй найзуудынхаа жагсаалтаас мөнгө илгээх болон нэхэмжлэх хүнээ сонгон, гүйлгээний утгаа оруулаад "Илгээх эсвэл Нэхэмжлэх" товч дарна.

Нэмэлт боломж: GPS байршил ашиглан өөрт хамгийн ойр байгаа хүн рүүгээ мөнгө илгээх боломжтой.

> 4 орон бүхий Сошиал пин кодоо оруулж гүйлгээгээ баталгаажуулна.

Эсвэл Touch ID буюу хурууны хээгээр гүйлгээг баталгаажуулна.

Шилжүүлэгч болон хүлээн авагчид Push notification, и-мэйл гэсэн хоёр сувгаар мэдээлэл очно. Мөн нэмэлтээр шилжүүлэгч ямар суваг ашиглан гүйлгээ хийхээс хамааруулан тэр сувгаар нь хүлээн авагчид давхар мэдээлл өгнө.



"Лавлагаа" буюу зурган дээрх icon дээр дарна.

Ямар найз руугаа мөнгө илгээсэн болон нэхэмжилсэн болох нь жагсаалт байдлаар харагдана. Тухайн найзынхаа мэдээлэл дээр дарснаар дэлгэрэнгүй байдлаар харах боломжтой.

Найз руугаа хэзээ, хэдэн удаа, хэдэн төгрөг илгээсэн эсвэл түүнээс нэхэмжилсэн болох, гүйлгээ амжилттай болсон эсэхийг харах боломжтой.

Нэмэлт боломж: Найзуудтайгаа чатлах боломжтой.

Таны илгээсэн нэхэмжлэх 14 хоног хүчинтэй ба энэ хугацаанд хүлээн авагч "Төлөх, Татгалзах" боломжтой. Мөн та хүссэн үедээ тухайн нэхэмжлэхийг "Цуцлах" боломжтой.

ОНЛАЙНААР ГОЛОМТ БАНКНЫ ХАРИЛЦАГЧ БОЛОХ

Аппликейшний "Бүртгүүлэх Бусад хэрэглэгч" сонголтыг сонгож зааврын дагуу мэдээллүүдээ оруулна.

Танд автоматаар харилцах данс нээгдэж, Интернэт банк болон SocialPay үйлчилгээний эрх олгогдоно.

